



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 45 (378)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Зарим яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны арванхоёрдугаар сарын 7 №45 (378)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

431. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Дугаар 25 804

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

432. Зарим шүүгчийг Улсын дээд шүүхийн  
шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 175 806
433. Ч. Тунгалагийг шүүгчийн албан  
тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 176 806
434. П. Даш, О. Үржин нарыг цэргийн  
жинхэнэ албанаас чөлөөлөх тухай Дугаар 177 806
435. О. Зандрааг УДШ-ийн Захиргааны хэргийн  
танхимын тэргүүнээр томилох тухай Дугаар 179 807

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

436. Барилга, хот байгуулалтын яамны зохион  
байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги,  
зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн  
хөтөлбөр батлах тухай Дугаар 201 807
437. Зам, тээвэр аялал жуулчлалын яамны зохион  
байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги,  
зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн  
хөтөлбөр батлах тухай Дугаар 202 816
438. Түлш, эрчим хүчний яамны зохион  
байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги,  
зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн  
хөтөлбөр батлах тухай Дугаар 203 823

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28.1-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16.2-т оруулсан өөрчлөлттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай:

**1/ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:**

1. Горчинсүрэнгийн Адъяа
2. Ринчиннямын Амаржаргал
3. Дашжамцын Арвин
4. Цогтын Батаа
5. Батын Батбаатар
6. Сүхбаатарын Батболд
7. Жамъяндоржийн Батхуяг
8. Гаваагийн Батхүү
9. Төгсжаргалын Ганди
10. Лүймэдийн Гансүх
11. Раднаасүмбэрэлийн Гончигдорж
12. Данзангийн Лүндээжанцан
13. Аукетайн Мурат
14. Цэндийн Нямдорж
15. Доржийн Одбаяр
16. Лувсангийн Одончимэд
17. Санжаасүрэнгийн Оюун
18. Кадырын Саираан
19. Мишигийн Сономпил
20. Данзандаржаагийн Туяа
21. Дэндэвийн Тэрбишдагва
22. Цэрэнхүүгийн Шаравдорж
23. Намбарын Энхбаяр
24. Нямаагийн Энхболд
25. Мэндсайханы Энхсайхан
26. Ономоогийн Энхсайхан

**2/ Байгаль орчны байнгын хороо:**

1. Рагчаагийн Бадамдамдин
2. Түнжингийн Бадамжунай
3. Батжаргалын Батбаяр
4. Сундуйн Батболд
5. Халтмаагийн Баттулга
6. Гаваагийн Батхүү
7. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
8. Ламжавын Гүндалай
9. Лханаасүрэнгийн Пүрэвдорж
10. Чойжамцын Раднаа
11. Кадырын Саираан
12. Цэгмидийн Цэнгэл
13. Цэрэнхүүгийн Шаравдорж

**3/ Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо:**

1. Чилхаажавын Авдай
2. Агыпарын Бакей

3. Сүхбаатарын Батболд
4. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
5. Төгсжаргалын Ганди
6. Раднаасүмбэрэлийн Гончигдорж
7. Долцонгийн Дондог
8. Самбуугийн Ламбаа
9. Рэгжийбуугийн Нямсүрэн
10. Чойнзонгийн Содномцэрэн
11. Аюурзанын Цанжид
12. Батаагийн Цэрэнбалжир
13. Баатарын Эрдэнэсүрэн

**4/ Дэд бүтцийн байнгын хороо:**

1. Дашжамцын Арвин
2. Батын Батбаатар
3. Батжаргалын Батбаяр
4. Сүхбаатарын Батболд
5. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
6. Цэвэлмаагийн Баярсайхан
7. Рэнцэнгийн Буд
8. Лүймэдийн Гансүх
9. Цэрэндашийн Дамирлан
10. Дамдины Дэмбэрэл
11. Цэрэнгийн Жаргал
12. Будээгийн Мөнхтуяа
13. Жанлавын Наранцацралт
14. Дүрээгийн Одхүү
15. Раднаабазарын Раш
16. Мишигийн Сономпил
17. Чүлтэмийн Улаан
18. Цэгмидийн Цэнгэл
19. Нямаагийн Энхболд
20. Бадарчийн Эрдэнэбат

**5/ Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн байнгын хороо:**

1. Ринчиннямын Амаржаргал
2. Надмидын Баяртсайхан
3. Сангажавын Баярцогт
4. Рэнцэнгийн Буд
5. Лувсанямын Гантөмөр
6. Мөнхчулууны Зоригт
7. Цэндийн Мөнх-Оргил
8. Цэндийн Нямдорж
9. Сайнбуянгийн Отгонбаяр
10. Кадырын Саираан
11. Дэндэвийн Тэрбишдагва
12. Баатарын Эрдэнэсүрэн

**6/ Нийгмийн бодлогын байнгын хороо:**

1. Горчинсүрэнгийн Адъяа
2. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
3. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
4. Лувсанямын Гантөмөр
5. Даваажавын Ганхуяг
6. Долоонжингийн Идэвхтэн
7. Самбуугийн Ламбаа

8. Бүдээгийн Мөнхтуяа
9. Рэгжийбуугийн Нямсүрэн
10. Лувсангийн Одончимэд
11. Санжаасүрэнгийн Оюун
12. Цэндийн Сүхбаатар
13. Данзандаржаагийн Туяа
14. Равжихийн Эрдэнэбүрэн

22. Цэндийн Сүхбаатар
23. Данзандаржаагийн Туяа
24. Чүлтэмийн Улаан
25. Ухнаагийн Хүрэлсүх
26. Аюурзанын Цанжид
27. Батаагийн Цэрэнбалжир
28. Намбарын Энхбаяр
29. Нямаагийн Энхболд
30. Ономоогийн Энхсайхан
31. Бадарчийн Эрдэнэбат
32. Равжихийн Эрдэнэбүрэн
33. Баатарын Эрдэнэсүрэн

## 7/ Төрийн байгуулалтын байнгын хороо:

1. Горчинсүрэнгийн Адъяа
2. Дашжамцын Арвин
3. Түнжингийн Бадамжунай
4. Нямжавын Батбаяр
5. Сундуйн Батболд
6. Эрдэнийн Бат-Үүл
7. Цэвэлмаагийн Баярсайхан
8. Надмидын Баяртсайхан
9. Лувсаннъямын Гантөмөр
10. Лүймэдийн Гансүх
11. Даваажавын Ганхуяг
12. Ламжавын Гүндалай
13. Долцонгийн Дондог
14. Дамдины Дэмбэрэл
15. Долоонжингийн Идэвхтэн
16. Самбуугийн Ламбаа
17. Данзангийн Лүндээжанцан
18. Аукетайн Мурат
19. Жанлавын Наранцацралт
20. Цэндийн Нямдорж
21. Доржийн Одбаяр
22. Дүрээгийн Одхүү
23. Сайнбуянгийн Отгонбаяр
24. Санжаасүрэнгийн Оюун
25. Чойжамцын Раднаа
26. Раднаабазарын Раш
27. Ядамсүрэнгийн Санжмятав
28. Мишигийн Сономпил
29. Ухнаагийн Хүрэлсүх
30. Аюурзанын Цанжид
31. Намбарын Энхбаяр
32. Мэндсайханы Энхсайхан

## 8/ Төсвийн байнгын хороо:

1. Ринчиннъямын Амаржаргал
2. Рагчаагийн Бадамдамдин
3. Түнжингийн Бадамжунай
4. Агьпарын Бакей
5. Нямжавын Батбаяр
6. Эрдэнийн Бат-Үүл
7. Жамъяндоржийн Батхуяг
8. Цэвэлмаагийн Баярсайхан
9. Надмидын Баяртсайхан
10. Сангажавын Баярцогт
11. Долцонгийн Дондог
12. Дамдины Дэмбэрэл
13. Базарсадын Жаргалсайхан
14. Гомбожавын Занданшатар
15. Мөнхчулууны Зоригт
16. Жанлавын Наранцацралт
17. Лувсангийн Одончимэд
18. Сайнбуянгийн Отгонбаяр
19. Түвдэнгийн Очирхүү
20. Лханаасүрэнгийн Пүрэвдорж
21. Ядамсүрэнгийн Санжмятав

## 9/ Хууль зүйн байнгын хороо:

1. Батын Батбаатар
2. Батжаргалын Батбаяр
3. Эрдэнийн Бат-Үүл
4. Халтмаагийн Баттулга
5. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
6. Сангажавын Баярцогт
7. Төгсжаргалын Ганди
8. Раднаасүмбэрэлийн Гончигдорж
9. Цэрэнгийн Жаргал
10. Базарсадын Жаргалсайхан
11. Данзангийн Лүндээжанцан
12. Цэндийн Мөнх-Оргил
13. Доржийн Одбаяр
14. Түвдэнгийн Очирхүү
15. Ухнаагийн Хүрэлсүх
16. Цэрэнхүүгийн Шаравдорж
17. Мэндсайханы Энхсайхан
18. Равжихийн Эрдэнэбүрэн

## 10/ Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:

1. Чилхаажавын Авдай
2. Рагчаагийн Бадамдамдин
3. Агьпарын Бакей
4. Цогтын Батаа
5. Сундуйн Батболд
6. Халтмаагийн Баттулга
7. Гаваагийн Батхүү
8. Цэрэндашийн Дамиран
9. Цэрэнгийн Жаргал
10. Мөнхчулууны Зоригт
11. Гомбожавын Занданшатар
12. Аукетайн Мурат
13. Рэгжийбуугийн Нямсүрэн
14. Чойжамцын Раднаа
15. Раднаабазарын Раш
16. Ядамсүрэнгийн Санжмятав
17. Чойзонгийн Содномцэрэн
18. Цэгмидийн Цэнгэл

## 11/ Эдийн засгийн байнгын хороо:

1. Чилхаажавын Авдай
2. Цогтын Батаа
3. Нямжавын Батбаяр
4. Жамъяндоржийн Батхуяг
5. Рэнцэнгийн Буд
6. Даваажавын Ганхуяг
7. Ламжавын Гүндалай
8. Цэрэндашийн Дамиран

9. Базарсадын Жаргалсайхан
10. Гомбожавын Занданшатар
11. Долоонжингийн Идэвхтэн
12. Цэндийн Мөнх-Оргил
13. Бүдээгийн Мөнхтуяа
14. Дүрээгийн Одхүү
15. Түвдэнгийн Очирхүү
16. Лханаасүрэнгийн Пүрэвдорж
17. Чойнзонгийн Содномцэрэн
18. Цэндийн Сүхбаатар
19. Дэндэвийн Тэрбишдагва
20. Чүлтэмийн Улаан
21. Батаагийн Цэрэнбалжир
22. Ономоогийн Энхсайхан

23. Бадарчийн Эрдэнэбат  
 2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай" Улсын Их Хурлын 2004 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Пүрэвийн Цэцгээ нарыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

Дуламын Пунцаг, Чулууны Тунгалаг,

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

**Ч. Тунгалагийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Чулууны Тунгалагийг

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

**П. Даш, О. Үржин нарыг цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх тухай**

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 92 дугаар зарлигаар батлагдсан "Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл", 1999 оны 41 дүгээр зарлигаар батлагдсан "Цэргийн цол олгох журам"-ын "Дөрөв" дэх хэсгийн 2<sup>11</sup> дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

хошууч генерал Одхүүгийн Үржин нарыг цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр чөлөөлсүгэй.

Гомшгаас хэмгээлэ: ерөнхий газрын дарга, хошууч генерал Пүрэвийн Даш, тэргүүн дэд дарга

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

### О.Зандрааг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын тэргүүнээр томилох ухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг тус тус баримтлан, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Захиргааны хэргийн танхимын тэргүүнээр томилсугай.

Оросоогийн Зандрааг Улсын дээд шүүхийн

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 10 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

### Барилга, хот байгуулалтын яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

4. Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төвийг байгуулж түүнийг үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих зарчмаар ажиллуулан зохион байгуулалтын бүтэц, дүрмийг баталж мөрдүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаярт даалгасугай.

1. Барилга, хот байгуулалтын яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

5. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч шинэчлэн батлагдсантай холбогдуулан Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу татан буулгах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаярт даалгасугай.

-Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар /Нутагшилт, суурьшлын хэлтэстэй/;

-Газрын харилцаа, эрхийн бүртгэлийн бодлого, зохицуулалтын газар /Газар өмчлөлийн хэлтэстэй/;

-Барилга, нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар /Орон сууцны зээлийн хэлтэстэй/;

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай" Засгийн газрын 2000 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 191 дүгээр тогтоол, "Яамдын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2003 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.7-г хүчингүй болсонд тооцсугай.

-Төрийн захиргаа, удирдлагын газар.

2. "Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

3. Барилга, хот байгуулалтын яамны орон тооны хязгаарыг 80, зардлын төсвийн хязгаарыг 318.0 /гурван зуун арван найман/ сая төгрөг байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙД

Н.БАТБАЯР

## Засгийн газрын 2004 оны 201 дүгээр тогтоолын хавсралт

### БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

#### 1. Нийтлэг үндэслэл

##### 1.1. Оршил

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-т Барилга, хот байгуулалтын сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, хэрэгжилтийг зохицуулалтаар хангах, эдийн засаг, хяналт-шинжилгээ хийх үр дүнг үнэлэх асуудлыг хамарсан Барилга, хот байгуулалтын яамны стратеги болон бүтцийн загварыг тодорхойлов.

##### 1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг УИХ-ын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг үндэслэв.

##### 1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль
- Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль
- Монгол Улсын Барилгын тухай хууль
- Монгол Улсын Хот байгуулалтын тухай хууль
- Монгол Улсын Газрын тухай хууль

· Монгол Улсын Орон сууцны тухай хууль

· Монгол Улсын Орон сууц хувьчлах тухай хууль

· Монгол Улсын Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль

· Монгол Улсын Хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль

· Монгол Улсын Геодези, зураг зүйн тухай хууль

· Монгол Улсын Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль

· Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэчийг сонгох журмын тухай хууль

· Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

· Ерөнхий бүдүүвчийг баталсан бусад хууль тогтоомж

##### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын туршлага, салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэлт өөрчлөлт, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн арга зүйг хэрэглэв.

##### 1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын хуваарь

Барилга, хот байгуулалтын яам Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд үүрэг хүлээж Барилга, хот байгуулалтын сайд, Засгийн газрын танхимд бүх талын зөвлөлгөө дэмжлэг үзүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яам салбарын бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалт болон төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яам нь Засгийн газрын Барилга, хот байгуулалтын зөвлөхийн үүрэг хүлээнэ.

##### 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Барилга, хот байгуулалтын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь дор дурдсан хүрээний үйлчлүүлэгч, хэрэглэгчийг хамаарна:



Барилга, хот байгуулалтын яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Барилга, хот байгуулалтын сайд, Засгийн газрын танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харьцааг эрх зүйн орчны хүрээнд зохицуулахад чиглэгдэнэ.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа нь төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд явагдана.

Төсвийн ерөнхийлөн захирагч (Барилга, хот байгуулалтын сайд)-тай төсвийн ерөнхий менежер (Төрийн нарийн бичгийн дарга) бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулан дүгнэж ажиллана.

Барилга, хот байгуулалтын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр бүрээр тогтоож яамны зохион байгуулалтын бүтцийн зорилт, чиг үүргийг үйл ажиллагаа /бизнес/-ны хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан нарийвчлан тогтоож, төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг гаргаж хэрэгжүүлнэ.

2. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги

## 2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх ажлын хүрээний асуудлыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Барилга, хот байгуулалтын сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

## 2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Барилга, хот байгуулалтын яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Хот, тосгоны хамгийн үр ашигтай тогтолцоог бий болгон хөгжүүлэх;

2. Газрын харилцаа, геодези зураглалыг зохистой бодлогоор удирдах, иргэн бүрт газрыг хувьчлах, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

3. Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн бүртгэлийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх;



4. Барилга, нийтийн аж ахуйн үйлчилгээг хэтийн болон ойрын зорилгоор хөгжүүлж хүн амыг тохилог орон сууцаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын бодлого чиглэлийг гаргаж салбарын хэмжээнд хэрэгжүүлэх.

## 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго:

*Монгол Улсын хот байгуулалт, газрын харилцааны оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар салбарын үр ашиг, бүтээмж, чанар болон орон сууцны хангамжийг дээшлүүлэхэд оршино.*

## 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Барилга, хот байгуулалтын яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Хот байгуулалтын үйл ажиллагааг бодлого, зохицуулалтаар хангах;

2. Газар, геодези, зураг зүй болон эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлтэй холбогдсон харилцааг бодлого, зохицуулалтаар хангах;

3. Барилга, орон сууц, нийтийн аж ахуйг бодлого, зохицуулалтаар хангах;

4. Төрийн захиргааны удирдлагыг хангаж салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх.

## 2.5 Үйл ажиллагааны гол зорилт

Барилга, хот байгуулалтын яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан зорилтыг дэвшүүлж ажиллана:

1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. Нутагшилт, суурьшлын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

1.2. Хот тосгоны тогтолцоог боловсруулж хэрэгжүүлэх.

2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Газрын харилцааны бодлого, зохицуулалтын удирдлагаар хангах;

2.2. Геодези, зураг зүйн бодлого боловсруулж зохицуулалтын удирдлагаар хангах;

2.3. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх бодлого, зохицуулалтаар хангах.

3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Барилгажилт, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, зохицуулалтаар хангах;

3.2. Орон сууцаар хангах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх асуудлыг зохицуулах;

3.3. Нийтийн аж ахуйн үйлчилгээг хөгжүүлэх бодлого, зохицуулалтаар хангах.

4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1. Төрийн захиргааны удирдлагыг хангах;

4.2. Хүний нөөцийн удирдлагыг хангах;

4.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохицуулах;

4.4. Салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

4.5. Салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх.


## 2.6. Үйл ажиллагааны зорилт

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

## 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



3. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн чиг, үүрэг:

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа, бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратеги зорилттой уялдсан байх);

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх,

нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);


6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (Барилга, хот байгуулалтын яамны төрийн захиргааны албан хаагч нь сайд, Засгийн газар (танхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэжлийн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх);

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхи бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээрх зарчим болон Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

### Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



тухайтбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

4. Бүтцийн нэгж энгийн байх (Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн (хоёроос дээшгүй) шат дамжлагатай байх);

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх. Энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад

3.3. Зохион байгуулалтын бүтэц

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яам зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжтэй байна.

#### I. ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Эрхлэх асуудал:

1. Хот байгуулалт, төлөвлөлт, бодлого, зохицуулалт

1. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн төсөл, хот байгуулалтын талаархи төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавих;
2. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн төсөл, эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төслийг боловсруулж батлуулах арга хэмжээ авах;
3. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрт мэргэжлийн дүгнэлт, үнэлэлт өгөх.

## 2. Хот байгуулалтын бодлого, зохицуулалт

1. Хот байгуулалтын төрийн бодлогын хүрээнд улс, бүс нутаг, хот, тосгоны тогтвортой хөгжлийг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах;
2. Хот байгуулалтын дүрэм, журам, норм, стандартыг боловсруулж батлуулах асуудлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, хот байгуулалтын баримт бичигт улсын экспертизийн дүгнэлт гаргах;
3. Барилгажих газрын асуудалд хяналт тавих;
4. Аж ахуйн нэгж, байгууллагад хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох, хэрэгжилтэд хяналт тавих.

## П. БАРИЛГА, НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

### Эрхлэх асуудал:

1. Барилгын талаархи төрийн бодлого, барилгын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

1. Барилгын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
2. Барилгын норм, дүрэм, барилгын төсвийн жишиг үнэлгээг боловсруулж батлуулах асуудлыг зохион байгуулах, стандарт хянах, мөрдүүлэх;
3. Барилгын норм, дүрэм боловсруулах, шинэчлэх хөрөнгийн эх үүсвэрийг барилгын өртөгт тусгах замаар нормчлолын сан бүрдүүлэх, түүнийг зориулалтынх нь дагуу зарцуулахад хяналт тавих;
4. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд

тусгай зөвшөөрөл олгож байгаа байдалд хяналт тавих.

2. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт

1. Барилгын салбарын техник, технологийн шинэчлэлтийн асуудал;
2. Барилгын салбарт шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, мэргэжлийн зэрэг олгох асуудлыг шийдвэрлэх;
3. Барилга архитектур, зураг төсөл, хайгуулын асуудал, баталгаажуулалт;
4. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга-угсралтын ажил, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохион байгуулах, хяналт тавих;
5. Засгийн газрын шугамаар гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барилгын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар санал боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах.

3. Болзошгүй газар хөдлөлөөс урьдчилан сэргийлэх бодлого

1. Газар хөдлөлтийн болон бусад гадны нөлөөллөөс хэв гажилт, эвдрэлд орсон барилга, байгууламжид техникийн дүгнэлт, инженерийн шийдэл гаргах, баталгаажуулах арга хэмжээ авах;
2. Газар хөдлөлтийн бүс нутагт барих барилга, байгууламжтай холбоотой норм, дүрэм, журмыг боловсруулж батлуулах.

4. Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

1. Орон сууцны төлөвлөлт, ашиглалтын норм, нормативыг боловсруулж батлуулах арга хэмжээ авах;
2. Орон сууц хөгжүүлэх улсын сангийн үйл ажиллагааг зохицуулан удирдаж, хяналт тавих;
3. Орон сууцны тухай хууль тогтоомж, дүрэм, заавар, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих;
4. Орон сууцны мэдээллийн нэгдсэн сан байгуулах;



5. Орон сууцыг хувьчилсны дараахь төрийн өмчийн орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, ажлын харилцан уялдааг зохицуулах.

5. Ипотекийн үйл ажиллагааны удирдлага, бодлого зохицуулалт

1. Ипотекийн дүрэм, журам, зааврыг боловсруулж мөрдүүлэх;
2. Ипотекийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох.

6. Нийтийн аж ахуйн салбарын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх

1. Нийтийн аж ахуйн салбарын талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;
2. Нийтийн аж ахуйн салбарт хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих асуудал;
3. Нийтийн аж ахуйн салбарын ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой норм, дүрэм, журмыг боловсруулж батлуулах арга хэмжээ авах;
4. Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах асуудалд хяналт тавих.

7. Нийтийн аж ахуйн салбарын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өргөтгөх хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөлт, бодлого, зохицуулалт;
2. Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарт хэрэгжиж буй төслүүдийн удирдлага, зохицуулалт;
3. Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарт шинээр хэрэгжих төслүүдийн үндэслэл, санал боловсруулах;
4. Нийтийн аж ахуйн салбарын техник, технологийн шинэчлэлтийн асуудал;
5. Нийтийн аж ахуйн салбарын инженерийн байгууламжийн туршилт тохируулгын ажил;
6. Хот тохижилт, хог хаягдлын асуудал;
7. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгож байгаа байдалд хяналт тавих.

## Ш. ГАЗРЫН ХАРИЛЦАА, ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Эрхлэх асуудал:

1. Газрын харилцааны талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, зохицуулалт

1. Газрын харилцааг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах;
2. Газрын талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг удирдлагаар хангах;
3. Газрын харилцаа, газар зохион байгуулалтын үйл ажиллагааны норм, дүрмийн талаар явуулах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;
4. Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохион байгуулах, хяналт тавих;
5. Иргэдэд газар өмчлүүлэх хувийн өмчийн газрын харилцааны талаархи бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
6. Газрын нэгдсэн сан, газрын кадастрын үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах.

2. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи бодлого, зохицуулалт

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийг зурагжуулах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;
2. Геодези, зураг зүйн талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;
3. Геодези, зураг зүйн холбогдолтой дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
4. Нууцын зэрэглэлтэй зургийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд хяналт тавих ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах;

3. Газрын кадастрын үйл ажиллагааг эрхлэх, бодлого, зохицуулалт

1. Кадастрын зураглалд ашиглагдаж байгаа зураг, мэдээллийн нууцыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хамгаалах ажилд хяналт тавихад сэрлэх;

2. Газрын кадастрын зураглалын мэдээллийн улсын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих.
4. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн бодлого, зохицуулалт
  1. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг зохион байгуулах;
  2. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн дүн мэдээнд дүн шинжилгээ, судалгаа хийх, үүний үндсэн дээр эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаархи бодлого боловсруулах;
  3. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн ажлын тайлан, төлөвлөгөөнд хяналт тавих;
  4. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх, бодлого, зохицуулалтаар хангах.
2. Салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
  1. Яам, салбарын сурталчилгаа, хэвлэл мэдээллийн асуудал;
  2. Яамны дотоод сүлжээний найдвартай ажиллагааг хангаж, мэдээ тайланг нэгтгэх.
3. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт
  1. Төрийн албан хаагчийн хэрэгцээг тодорхойлох, тэднийг бэлтгэх, үр дүнийг гэрээ байгуулах, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх, мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон асуудал боловсруулах, хэрэгжүүлэх;
  2. Салбарын болон аппаратын ажиллагсдын шагнал урамшууллын асуудлыг боловсруулах;
  3. Сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах арга хэмжээг авах.

## IY. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР

### Эрхлэх асуудал:

#### 1. Яамны аппаратын дотоод ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах

1. Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, захирамж, сайдын болон яамны удирдлагын тушаал шийдвэр, удирдах дээд байгууллагын үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;
2. Яамны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан мөрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;
3. Сайд болон яамны удирдлагад шаардлагатай мэдээлэл, хууль эрх зүйн зөвлөлтгөөгөөр хангах;
4. Албан хэрэг хөтлөлт, архив, нууцын асуудлыг хариуцан яаманд гаргасан санал, гомдол, өргөдлийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
5. Салбарын өндөр настны талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.

#### 4. Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудал

1. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах асуудлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;
2. Салбарын хэмжээнд хэрэгжүүлэх гадаадын эзэл, тусламж, эдийн засгийн хамтын ажиллагааны стратеги, хөтөлбөрийг холбогдох газруудтай хамтран боловсруулах;
3. Сайд, удирдлагын гадаад албан томилолт, гадаадын зочин төлөөлөгчийг хүлээн авах ажлын бэлтгэл хангах.

#### 5. Төсвийн удирдлага, санхүүжилттэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

1. Салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг улсын төсвийн төсөлтэй уялдуулан боловсруулах;
2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн



- бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Салбарын үйл ажиллагааны төвлөрсөн болон төвлөрсөн бус статистикийн мэдээлэл гаргах, хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах.
  - Хяналт-шинжилгээний ажлыг сайжруулж, гүйцэтгэлийг хангуулах
    - Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа агентлаг, өөрийн аппаратын үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн хяналт шалгалтыг зохион байгуулах;
    - Хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээр, төрийн өмчийн эд хөрөнгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх;
    - Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбар, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
    - Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
    - Сайдад нийлүүлэх бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт, түүний чанар, тоо хэмжээ, өртөг, хугацаа, хүрэх түвшинг хянаж, дүгнэх.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 10 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 202

Улаанбаатар хот

**Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

- Авто замын бодлого, зохицуулалтын газар;

- Тээврийн бодлого, зохицуулалтын газар /Авто тээврийн хэлтэстэй/;

- Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газар;

- Шуудангийн үйлчилгээний бодлого, зохицуулалтын газар;

- Эдийн засаг, хамтын ажиллагааны газар;

- Төрийн захиргаа, удирдлагын газар /Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй/.

2. Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

3. Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны орон тооны хязгаарыг 80, зардлын хязгаарыг /монгол орныг гадаадад сурталчлах болон хөтөлбөр, төслийн дотоод урсгал зардал, олон улсын байгууллагын гишүүний татварыг оролцуулахгүйгээр/ 318.0 (гурван зуун арван найман) сая төгрөг байхаар тогтоосугай.

4. Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Тээврийн үйлчилгээний төв, Авто замын хяналт, судалгааны төвийг тус тус байгуулж тэдгээрийг үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих зарчмаар ажиллуулан зохион байгуулалтын бүтэц, дүрмийг баталж мөрдүүлэхийг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Г.Батхүүд даалгасугай.

5. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч шинэчлэн батлагдсантай холбогдуулан Авто замын газар, Аялал жуулчлалын газар, Тээврийн газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу таган буулгах арга хэмжээ авахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Г.Батхүүд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Г.БАТХҮҮ**

Засгийн газрын 2004 оны 202 дугаар  
тогтоолын хавсралт

## ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР

### 1.0. Нийтлэг үндэслэл

#### 1.1. Оршил

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-т Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

-Монгол Улсын Авто тээврийн тухай хууль

-Монгол Улсын Далай ашиглах тухай хууль

-Монгол Улсын Шуудангийн тухай хууль

-Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хууль

-Монгол Улсын Усан замын тээврийн тухай хууль

-Монгол Улсын Радио долгионы тухай хууль

-Монгол Улсын Авто замын тухай хууль

-Бусад хууль тогтоомж

#### 1.4 Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт, дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн болон урьд хуримтлагдсан арга зүй, мэдээллийг ашиглав.

#### 1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын хуваарь

Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд үүрэг хүлээж, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, дэд сайд, Засгийн газрын танхимд бүх талын зөвлөлтөө, дэмжлэг үзүүлнэ.

Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь салбарын бодлого, төлөвлөлт болон төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь эрхэлсэн асуудлын чиглэлээр Засгийн газрын зөвлөхийн үүрэг хүлээнэ.

#### 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.

### 1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг боловсруулав.

#### 1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

-Монгол Улсын Үндсэн хууль

-Монгол Улсын Засгийн газрын тухай хууль

-Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль

-Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль

-Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

-Монгол Улсын төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль

-Монгол Улсын Төрийн албаны тухай хууль


-Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хууль

-Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль

-Монгол Улсын төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль



## ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, дэд сайд, Засгийн газрын танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулахад чиглэнэ.

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон, тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн

зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.0. Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын үйл ажиллагаанд өндөр

мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

## 2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Зам, тээврийн оновчтой сүлжээ, аялал жуулчлал, шуудангийн үйлчилгээг өргөтгөх, эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн сүлжээний үндсийг бий болгох

2. Салбарын удирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг боловсронгуй болгох

3. Тухайн салбарт хувийн хэвшлийг дэмжиж, өмчийн олон хэлбэрийн өрсөлдөх орчинг бий болгох

4. Бүх төрлийн тээврийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, ажлын уялдааг сайжруулах

5. Салбарын эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх

6. Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих

## 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны эрхэм зорилго:

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээврийн сүлжээ, аялал жуулчлал, шуудангийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх

## 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Салбарын төлөвлөлт, бодлого, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдамжаар хангах

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

3. Салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх

4. Салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх

## 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны

стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1 Салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах

1.2 Салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах

1.3 Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

2.2 Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах

Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1 Салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх

3.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг хангуулах

Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1 Салбарын эдийн засгийн бодлого, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын төлөвлөлт, зохицуулалт, тайлагнах үйл ажиллагаа

4.2 Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх


## 2.6 Үйл ажиллагааны зорилт

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны гол зорилт бол тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

## 2.7 Үйл ажиллагааны стратегийн загвар

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

## ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



3.0. Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх)

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх)

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх)

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас

хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн (гурваас дээшгүй) шат дамжлагатай байх)

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх)

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар (танхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлд автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх)

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх)

### 3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

### ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТӨЛЦООНЫ ЗАГВАР



### 3.3. Зохион байгуулалтын бүтэц

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яамны зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжийг санал болгож байна:

1. Стратегийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгжүүд нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого, зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын төлөвлөлт, зохицуулалт, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжүүд байна.

Энэ нэгжүүдийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангах асуудлыг хариуцна.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжүүдийн үйл ажиллагаа нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлтөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжүүдээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Засгийн газрын танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн

нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

Энэ нэгжийн үйл ажиллагааны хүрээнд Авто зам, Тээвэр, Аялал жуулчлал, Эдийн засаг, хамтын ажиллагаа, Шуудангийн үйлчилгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн таван газар ажиллана.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайлыг хангах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, яамны аппаратын дотоод ажлыг зохицуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлтөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага байна.

3. Бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийж, үнэлж дүгнэх нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, эрхэлсэн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд төрийн захиргаа, удирдлагын газрын бүтцэд хэлтсийн зохион байгуулалтаар ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах,

төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тунш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 10 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Түлш, эрчим хүчний яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түлш, эрчим хүчний яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай;

-Эрчим хүчний бодлого, зохицуулалтын газар (Эрчим хүчний төлөвлөлт, зохицуулалтын хэлтэс, Сэргээгдэх эрчим хүчний хэлтэстэй);

-Түлшний бодлого, зохицуулалтын газар;

-Эдийн засаг, мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэстэй);

-Төрийн захиргаа, удирдлагын газар (Хамтын ажиллагааны хэлтэстэй).

2. Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

3. Түлш, эрчим хүчний яамны орон тооны хязгаарыг 80, зардлын төсвийн хязгаарыг (хөтөлбөр, төслийн дотоод урсгал зардал, олон улсын байгууллагын гишүүний татварыг оролцуулахгүйгээр) 318.0 (гурван зуун арван найман) сая төгрөгөөр тогтоосугай.

4. Түлш, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төвийг байгуулж түүнийг үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих зарчмаар ажиллуулан зохион байгуулалтын бүтэц, дүрмийг баталж мөрдүүлэхийг Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүүд даалгасугай.

5. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүүдүүвч шинэчлэн батлагдсантай холбогдуулан Түлш, эрчим хүчний ерөнхий газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу татан буулгах арга хэмжээ авахыг Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ТҮЛШ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД

Т.ОЧИРХҮҮ

## ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР

### 1. Нийтлэг үндэслэл

-Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль

#### 1.1. Оршил

-Бусад хууль тогтоомжууд

Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-т Түлш, эрчим хүчний сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

#### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагааны /бизнес/ төлөвлөлт, дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн болон энэхүү бүтцээр ажиллах хугацаанд хуримтлагдсан арга зүй, мэдээллийг ашиглав.

### 1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг үндэслэн боловсруулав.

#### 1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын хуваарь

Түлш, эрчим хүчний яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг, хариуцлага хүлээж, Түлш, эрчим хүчний сайд, Засгийн газрын танхимд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

#### 1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

-Монгол Улсын Үндсэн хууль

-Монгол Улсын Засгийн газрын тухай хууль

-Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль

-Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль

-Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

-Монгол Улсын Төрийн албаны тухай хууль

-Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль

Түлш, эрчим хүчний яам нь салбарын бодлого төлөвлөлт, зохицуулалт, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоо хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Түлш, эрчим хүчний яам нь Засгийн газрын эрхэлсэн асуудлын чиглэлээр зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

#### 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Түлш, эрчим хүчний яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

## ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Түлш, эрчим хүчний яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Түлш, эрчим хүчний сайд, Засгийн газрын танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр заасан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн нийлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн цэгцтэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Түлш, эрчим хүчний яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байрны /албан тушаал/ тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги

### 2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Түлш, эрчим хүчний сайдын

эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Түлш, эрчим хүчний сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 2.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Түлш, эрчим хүчний яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана. Үүнд:

1.Түлш, эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгч эдийн засгийн өсөлтийг хангахуйц түлш, эрчим хүчний сүлжээний үндсийг бий болгох

2.Түлш, эрчим хүчний салбарын удирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх

3. Түлш, эрчим хүчний салбарт хувийн хэвшлийг дэмжих, энэ салбарт өмчийн олон хэлбэрийн өрсөлдөх орчинг бий болгох

4. Түлш, эрчим хүчний салбарт тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг хангаж, ажлын уялдааг сайжруулах



5. Түлш, эрчим хүчний салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх

6. Түлш, эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих

7. Салбарын эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх

8. Сэргээгдэх эрчим хүч ашиглах, дэмжих

9. Эдийн засгийн үр ашигтай эрчим хүчний хэмнэлттэй техник, технологи ашиглахыг дэмжих

2.3 Үйл ажиллагааны эрхэм зорилго

Улс орны эдийн засгийн өсөлтийг хангахуйц түлш, эрчим хүчний үйлдвэрлэл, үйлчилгээг найдвартай тогтвортой хөгжүүлэх

2.4 Үйл ажиллагааны стратегийн зорилт

Түлш, эрчим хүчний яам эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Түлш, эрчим хүчний салбарын стратегийн бодлого төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах удирдамжаар хангах

Төрийн захиргааны удирдлагыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

Түлш, эрчим хүчний салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, салбарын мэдээллийн сүлжээг хөгжүүлэх

Салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх

2.5 Үйл ажиллагааны гол зорилт

Түлш, эрчим хүчний яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. Түлш, эрчим хүчний салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бүтцийн шинэчлэлт хийх

1.2. Түлш, эрчим хүчний салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах

1.3. Түлш, эрчим хүчний үйлдвэрлэлт,

дамжуулалт, түгээлт, хангалт (компанийн засаглалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх)

1.4. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх

1.5. Бүс нутгийн түлш, эрчим хүчний хангалтыг сайжруулах, шинэчлэх

1.6. Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах

2.3. Түлш, эрчим хүчний салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх

Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх

3.2. Түлш, эрчим хүчний салбарын мэдээллийн сүлжээ хөгжүүлэх; сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах

3.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Түлш, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг хангуулах

Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1. Түлш, эрчим хүчний салбарын эдийн засаг, санхүүгийн нөөцийг хуваарилах, төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах

4.2. Салбарын эдийн засгийн бодлого, Түлш, эрчим хүчний сайдын төсвийн багцын төлөвлөлт, зохицуулалт, тайлагнах үйл ажиллагааг боловсронгуй болгох

2.6. Үйл ажиллагааны зорилт

Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны гол зорилт бол тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлсон байна:

## ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ /БИЗНЕС/ СТРАТЕГИЙН ЗАГВАР

Эрхэм зорилго

Үйл ажиллагааны  
стратегийн  
зорилт

Үйл ажиллагааны  
гол зорилт

1. Түлш, эрчим хүчний салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах удирдамжаар хангах

1.1. Түлш, эрчим хүчний салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бүтцийн шинэчлэлт хийх

1.2. Түлш, эрчим хүчний салбарын төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах

1.3. Түлш, эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлт, хангалт (компанийн засаглалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх)

1.4. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх

1.5. Бүс нутгийн түлш, эрчим хүчний хангалтыг сайжруулах, шинэчлэх

1.6. Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах

2.3. Түлш, эрчим хүчний салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх

3. Салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, салбарын мэдээллийн сүлжээг хөгжүүлэх

3.1. Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх

3.2. Түлш, эрчим хүчний салбарын мэдээллийн сүлжээ байгуулах, сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах

3.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Түлш, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгадаг арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангуулах

4.1. Түлш, эрчим хүчний салбарын эдийн засаг, санхүүгийн нөөцийг хуваарилгах, төсөл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах

4. Салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх

4.2. Салбарын эдийн засгийн бодлого, Түлш, эрчим хүчний сайдын төсвийн багцын төлөвлөлт, зарцуулалтын тайлагнах үйл ажиллагааг боловсронгуй болгох

Улс орны эдийн засгийн өсөлтийг хангахуйц түлш, эрчим хүчний үйлдвэрлэл, үйлчилгээг тогтвортой найдвартай хөгжүүлэх

Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн чиг үүрэг

3.1 Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим /тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх/

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой итгэл хүлээхүйц байх зарчим /бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх/

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим /байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх/

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим /тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас

хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн, гурваас дээшгүй шат дамжлагатай байх/

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим /байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх/


6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим /Тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар /Танхим/, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлд автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлтөө, дэмжлэг үзүүлэх/

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим /Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхи бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх/

3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагаа /бизнес/-ны загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

## ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



### 3.3. Зохион байгуулалтын бүтэц

Түлш, эрчим хүчний яамны үйл ажиллагаа, стратегийн болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яамны зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжийг санал болгож байна:

1. Стратегийн бодлого төлөвлөлт, зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

1.1. Түлшний бодлого, зохицуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг:

Түлшний салбарын стратегийн хөгжлийн хэтийн төлөв, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, түлшний салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах бодлогын хэрэгжилт зохицуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино.

Дээрх чиг үүргийн дагуу төв, орон нутгийн нүүрсний уурхайнуудыг өргөтгөх, шинэчлэх, шинээр барьж байгуулах, хатуу түлшний хангамжийг сайжруулах бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, зөвлөлгөө дэмжлэг үзүүлэх, түүнчлэн хатуу ба хий, шингэн түлшний хэрэглээ, хангамжийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн зохицуулалтын удирдамж, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах үүргийг гүйцэтгэнэ.

1.2. Эрчим хүчний бодлого, зохицуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг:

Эрчим хүчний салбарын хөгжлийн стратегийн нэгдсэн бодлогыг боловсруулах, эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт, хангалтын үйл ажиллагааг зохицуулах, эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгож ашиглах, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, бүс нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулахад оршино.

Энэ нэгж нь эрчим хүчний салбарын хөгжлийн хэтийн чиг хандлагыг тодорхойлох, урт, дунд, богино хугацааны хөтөлбөрийн хүрээнд дэс дараатай хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, эрчим хүчний салбарын удирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх, эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны бохирдлыг багасгахад чиглэгдсэн төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн зохицуулалтын удирдамж, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах чиг үүргийг гүйцэтгэнэ.

1.3. Энэ нэгжүүдийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Түлш, эрчим хүчний сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангах асуудлыг хариуцна.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжүүдийн үйл ажиллагаа нь Түлш, эрчим хүчний сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Түлш, эрчим хүчний сайд, Засгийн газрын танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Түлш, эрчим хүчний сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжүүдээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Түлш, эрчим хүчний сайд, Засгийн газрын танхим байх бөгөөд бусад бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь шууд яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Мөн Түлш, эрчим хүчний салбарын төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, уг мэдэгдлийг үндэслэн санхүүгийн нөөцийг хуваарилах, төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах, гадаадын зээл, тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх зэрэг болно.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж /Хамтын ажиллагааны хэлтэстэй/, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны



удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцоо тогтолцоог хөгжүүлэх, хамтын ажиллагааг зохицуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэгжийн бүтцэд хамтын ажиллагааны нэгж харьяалагдаж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, олон улсын байгууллагатай харьцах чиглэлийн үндсэн чиг үүргийг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Түлш, эрчим хүчний сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Түлш, эрчим хүчний сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны эсхион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бусад байгууллага байна.

3.Бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийж, үнэлж дүгнэх, төсөв, хөрөнгө

оруулалтыг зохицуулах нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн гурав, дөрөвдүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, түлш, эрчим хүчний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сүлжээ хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэгжийн бүтцэд эдийн засаг, хөрөнгө оруулалтын нэгж харьяалагдаж, салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалт, түлш, эрчим хүчний салбарын төсвийн багцын төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтын чиглэлийн үндсэн чиг үүргийг хүлээнэ.

Түүнчлэн энэ нэгжийн бүтцэд мэдээллийн технологийн нэгж харьяалагдаж, түлш, эрчим хүчний салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах, сан бүрдүүлж хөтлөх, салбарын WEB хуудас, салбарын мэдээллийг орчин үеийн шаардлага нөхцөлд нийцсэн байдлаар олон нийтэд хүртээмжтэй байдлаар боловсруулах үндсэн чиг үүргийг хүлээнэ.

Энэ нэгж нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Түлш, эрчим хүчний сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл  
Улаанбаатар- 12,  
Төрийн ордон  
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.  
☎ 329487  
Хэвлэлийн хуудас 3.5